

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН  
САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД  
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

/2017 оны хагас жил/

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.**

УИХ-ын 2016 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, Засгийн газрын 2017 оны 29 дугаар тогтоолоор батлагдсан, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээг хяналтанд авч ажиллаж байна. Уг төлөвлөгөөний дагуу макро эдийн засгийн бодлогын хүрээнд 6 зорилтын 26 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав.

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь төлөвлөгөөний гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж байна.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.**

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний ерөнхий гүйцэтгэл 2017 оны хагас жилийн байдлаар 72,3 хувьтай үнэллээ. Төлөвлөгдсөн арга хэмжээнээс 10 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 8 арга хэмжээ 70 хувь, 8 арга хэмжээ 40 хувийн тус тус хэрэгжилттэй байна. Тасарсан арга хэмжээ байхгүй болно.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ  
 ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
 ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧООН  
 /Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам/

(2017 оны хагас жил)

Бодлого	Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт, хувиар					Дундаж, %
			100	70	40	0	/-/	
НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлвийг судлах зорилгоор геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэх	9	3	4	2			73,3
	Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, Тавантолгойн орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ, хэлцлийг байгуулж, төслийн үйл ажиллагааг эхлүүлэх	4		1	3			47,5
	“Алт-2” хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг эхлүүлэх	3	3					100,0
	Ашиглахад бэлэн болсон уурхайн үйл ажиллагааг эхлүүлэх, олборлолт, экспортыг нэмэгдүүлэх	1		1				70,0
	Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	7	3	1	3			70,0
	Газрын тосны эрэл, хайгуул, олборлолтыг тогтвортой нэмэгдүүлж, газрын тос боловсруулах үйлдвэрийг барих бэлтгэл ажлыг хангах	2	1	1				85,0
<b>Нийт дундаж</b>		<b>26</b>	<b>10</b>	<b>8</b>	<b>8</b>			<b>72,3</b>

Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн төслүүдийн үр дүнг хүлээн авах, үргэлжлүүлэх, шинээр эхлүүлэх ажлуудыг төлөвлөсөн хугацаанд багтаан хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тайланг хүлээн авах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох төслүүдийн үр дүнг хүлээн авч иж бүрдэл зургийг нэгтгэх төслийг К хавтгайн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд “L хавтгайн хэмжээнд хэрэгжүүлэх” гэж тусгагдсан нь техникийн алдаа гарсантай холбоотой гэж үзэж байна.

Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын явц оны эхний хагас жилийн байдлаар хэдэн хувийн гүйцэтгэлтэй байгаа талаар тодорхой мэдээлэл алга байна.

Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээ хэлцлийг байгуулах ажлын явц удаашралтай, ажил эхлэлийн шатанд явж байна.

Ашиглахад бэлэн болсон уурхайн үйл ажиллагааг эхлүүлэх, улсын комиссоор хүлээн авснаар ашигт малтмалын олборлолт, экспортыг нэмэгдүүлэхэд ямар үр дүн гарсан талаарх мэдээлэл дутуу, бүрэн гүйцэд биш байна.

Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын явц мөн удаашралтай байна гэж үзлээ.

**Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж.**

Монгол улсын Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний ерөнхий гүйцэтгэл хагас жилийн байдлаар 72,3 хувьтай үнэлсэн ба тасарсан арга хэмжээ алга байна.

Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын явцын зорилтот түвшин 2017 онд 20 хувь байхаар төлөвлөгдсөн ч хагас жилээр ирүүлсэн биелэлтэд гүйцэтгэлийг хувиар тооцож гаргаагүй тул УУБГ анхаарч ажиллах нь зүйтэй.

Үлдэж байгаа хугацаанд төлөвлөгдсөн ажлуудын хэрэгжилтийг бүрэн хангаж удаашралтай байгаа ажлуудыг эрчимжүүлэх, биелэлтийг гүйцэд, үнэн зөв тайлагнах, зохион байгуулалтаа сайжруулах талаар нэгжийн дарга, мэргэжилтнүүд арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

2017/06/22